



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

2025 оны хурлын хэлэлцэх асуудал, ажлын
төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А-1/284 дүгээр удирдамж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.28 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар 2025 онд хэлэлцэх асуудал, ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Батчулуун/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Гэрэлзул/ нарт үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Н.ГАНБОЛД

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025
оны 02 дугаар сарын 11-ний
өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
2025 ОНД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, ажлын төлөвлөгөө	Хугацаа	Хариуцах нэгж
1.	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2025 онд хэлэлцэх асуудал, ажлын төлөвлөгөө батлах тухай	2025 оны 02 сар	ТУЗ-ийн Ажлын алба
2.	Багахангай – Хөшигийн хөндий – Шувуун фабрик чиглэлийн 102.5 км гол замын урттай салбар төмөр замын төслийн ажлын тухай	2025 оны 02 сар	Төсөл хөтөлбөр, судалгааны газар
3.	Цогтцэций – Зүүнбаян чиглэлийн төмөр замд мөрдөх тээврийн тарифын мөрдлөг, тарифын хөнгөлөлтийн тухай	2025 оны 02 сар	Тээвэр, ложистикийн төлөвлөлтийн газар
4.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	2025 оны 03 сар	Төлөөлөн удирдах зөвлөл
5.	Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитлагдсан санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргаж, Хувьцаа эзэмшигчид мэдэгдэх тухай	2025 оны 03-04 сар	Захиргаа, удирдлагын газар, ЭЗХОГ
6.	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай	2025 оны 03-04 сар	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс
7.	Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх тухай /ТӨБЗГ-ын 184 дүгээр тогтоол/	2025 оны 03-04 сар	Захиргаа, удирдлагын газар
8.	Компаниас хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагааны явцын тухай	2025 оны 05 сар 2025 оны 10 сар	Төсөл хөтөлбөр, судалгааны газар
9.	Төмөртэй – Хандгайт чиглэлийн төмөр замд мөрдөх тээврийн тариф болон тарифын мөрдлөгийн тухай	2025 оны 06 сар	Тээвэр, ложистикийн төлөвлөлтийн газар

10.	Компанийн өмчийн бүртгэл ашиглалт, санхүүгийн үйл ажиллагааны явцын тухай	2025 оны 07 сар, 2025 оны 12 сар	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс
11.	Компанийн 2024 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийн тухай		
12	Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт /хагас, бүтэн жил/	2025 оны 08, 12 сар	Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газар
13.	Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлах тухай	2025 оны 11- 12 сар	Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газар
14.	Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлах тухай	2025 оны 11- 12 сар	Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газар
15.	Компанийн хэрэгжүүлж буй төслүүдтэй холбоотой шийдвэр гаргах, төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудал, ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах бусад асуудал	Тухай бүр	Холбогдох газар, хэлтэс